

## МОНГОЛЫН БАРУУН БҮС НУТАГ ДАХЬ БУРХАНЫ ШАШНЫ СҮМ ХИЙД, НӨХЦӨЛ БАЙДЛЫН ШИНЖИЛГЭЭ

*Ц.Пүрэвсүрэн, доктор (Ph.D)*

*Ховд Их Сургууль*

*Нийгэм, хүмүүнлэгийн ухааны тэнхим*

*Түлхүүр үг: Шашин, уламжлалт шашин, уламжлалт бус шашин, бурханы шашин, шашны үнэлэмж, олон ургальч үзэл, сүм хийд, лам, хуврага, асуудал, шийдэл, нөхцөл байдал*

**Товч утга:** Эдүгээ Монгол оронд 1990-ээд оноос шашин шүтэх эрх чөлөө нээлттэй болсонтой холбогдон дан ганц шашингүйн үзэл ухамсар, эс бол буддын шашин ноёрхох шинжтэй бус харин дэлхийн олон шашны урсгал номлолууд зэрэгцэн орших болсон. Нэн ялангуяа орон нутагт бурханы шашны сүм хийдүүдийг сэргээн босгох, шинээр бүтээн байгуулах, нутаг орондоо суварга, шүтээн босгох үйл хэрэг их хүчтэй явагдсан. Гэвч орон нутагт компани, аж ахуйн нэгж, хувь хүмүүс, нутгийн олон түмний санаачлага, хандив тусламжаар байгуулагдсан бурханы шашны сүм хийдүүдийн үйл ажиллагаа, нөхцөл байдал ямар буйд дүн шинжилгээ хийхийг зорьсон болно. Баруун бүс нутаг угсаатны бүтцийн хувьд монголын хамгийн олон угсаатны бүлгүүд оршин амьдардаг онцлогтой. Энэ байдал ч сүм хийд, шашны байгууллага үйл ажиллагаа явуулах, зэрэгцэн орших, уламжлалт соёл заншлаа хадгалах, хамгаалах, сэргээн хөгжүүлэхэд тодорхой асуудлуудыг бий болгож байдаг. Зохиогч монголчуудын уламжлалт бурханы шашны сүм хийдүүдийг хадгалах, хамгаалах, үйл ажиллагааг нь тогтмолжуулахад чухам юуг анхаарах ёстойг авч үзсэн болно.

Шашны асуудал бол хүн төрөлхтний нийгэм, соёл ба иргэншлийн хөгжлийн нэг салшгүй хэсэг төдийгүй тухайн улс үндэстний үнэт зүйл, мөн чанар, уламжлал хийгээд шинэчлэл, хоцрогдол хийгээд дэвшил, хүн амын оюуны соёл, соён

гэгээрлийн ил тод нэгэн үзүүлэлт болж байдаг. Манай улс орны түүхээс харахад монголчуудын дунд шашны янз бүрийн урсгал чиглэлүүд үүсэн төлөвшиж, түгэн тархаж, нэр нөлөө нь өсөн нэмэгдэж, мандан бадарч, уруудан доройтож, зарим тохиолдолд тухайлсан зарим шашныг төрийн хуулиар цаазлан хорьж албан ёсоор хууль эрх зүйн хувьд хориглож иржээ.

Түүхэн талаасаа бүх шашинд адил тэгш хандах монгол их хаадын төрийн бодлогын үрээр их гүрний хэмжээнд олон шашнууд зэрэгцэн оршиж, сүм хийдээ барьж босгон, хүн ард нь эвтэй зохицон амьдарч байсан баримтууд олон байдаг. Тухайлбал, Жувейнигийн зохиосон “Дэлхийг байлдан дагуулагчийн түүх” хэмээх түүхэн сударт иш татаж тэмдэглэснээр “Их засаг” хуулийн хоёр зүйлд: “Тэд шашин бүрийн хамгийн номтой санваартнуудыг аливаа татвар, алба гувчуурын дарамтнаас чөлөөлж, тэдний шашны эд хэрэглэл, өмч хөрөнгийг бүх нийтийн хэрэгцээнд зориулан, мөн тэдний харьяалалд байсан тариачдыг элдэв татвараас чөлөөлнө гэж зарласан” гэсэн бол гучин дөрөвдүгээр зүйлд: “.. аль нэг шашныг ялган гадуурхдаггүй, алиныг нь ч онцлон дэмждэггүй, цөмийг нь адилхан үздэг байлаа.... Түүний хүүхдүүд, ач нар нь ямар шашин шүтэхээ өөрсдөө сонгоно. ...Тэд хэдийгээр өөр өөр шашинд орсон ч шашнаа улайран өмөөрч хоорондоо хямардаггүй, харин Чингис хааны Яаса хуулийг хэлбэрэлтгүй баримтлан эв эе их

сахидаг байлаа" гэжээ (Монголын хууль тогтоомжийн түүхэн эмхтгэл, 2010, хууд. 32).

Монгол оронд бурханы шашин хэзээ, хэрхэн дэлгэрсэн асуудал ХХ зууны эхэн үеэс түүхчдийн анхаарлыг татсаар иржээ.

Монголын уламжлалт түүх бичлэгийн гол төлөөлөгчдийн нэг Ш.Дамдин бээр (1867-1936) монгол, төвөд сурвалжид тулгуурлан 1931 онд бичсэн бурханы шашны түүхийн тухай бүтээлдээ Монголд бурханы шашин дэлгэрсэн түүхийг гурван үед хуваан авч үзсэн. Үүнд, нэгдүгээрт: Бурханы шашин анхлан дэлгэрсэн үе буюу Хүннү гүрэн, түүний дараах үе, хоёрдугаарт: Бурханы шашны дунд дэлгэрэлтийн үе буюу Их Монгол улс, Монголын эзэнт гүрний үе, гуравдугаарт: Бурханы шашны хожуу дэлгэрэлтийн үе буюу Алтан хан, Абтай сайн хааны үе (Зава Дамдин Лувсандаян, 2014, хууд. 40). Үүнээс хойш судлаачид Монголд бурханы шашин дэлгэрсэн түүхийг ерөнхийд нь дээр дурдсан гурван үед хувааж авч үзсээр иржээ.

Эдгээрээс “гурав дахь дэлгэрэлт”-ийн үеэс бурханы шашин богино хугацаанд нийт Монгол орны хэмжээнд тархан дэлгэрч, монголчуудын оюун санааны үндэс болжээ. Оюуны үнэт соёл, итгэл үнэмшил, үнэлэмж хийгээд үнэт зүйлийн тухайд нь шашнаар нэгтгэх гэсэн Монгол хаадын бодлого, үйл хэрэг нь эв найрамдалгүй, эх захаа алдсан дайн самуун, эрх мэдлийн төлөөх тэмцэл, эд баялгийн хойноос хөөцөлдсөн улангассан хүч зэргийг зогсоох гол арга зам гэдэг сонголтонд хүргэсэн. Мөн бурханы шашны талаар Академич Л.Хүрэлбаатар аругайн “Бурхан гэдгийг дээд тэнгэрээс сарвалзаж гуйхын ч хэрэггүй, гагц өөрийнхөө сэтгэлийн сайжрал, оюуны гэгээрлээс эрэх хэрэгтэй” гэж дүгнэсэн буддизмын онцлог нь нүүдэлчин монголчуудын оюун сэтгэлийн хөрсөнд идээших хөрс суурь илүү тохиромжтой байсанд оршино. Өөрөөр хэлбэл, дорно дахины буддизмын мөн чанарт монголчуудын нүүдлийн

соёлтой ижилсэх, аль аль нь нэг нэгэндээ өөриймшин уусах, шинэчлэгдэн хөгжих тийм онцлог байсан. Жишээ нь, дорны соёлын хүмүүнийг дэлхий ертөнцийн төв хэмээн сэтгэх, эрхэмлэх үзэлт, байгаль дэлхий сав шим ертөнцийг хүмүүнчлэн үзэх гэх мэт. Нөгөө талаар Төвөд, Манжийн төрийн бодлогын уршгаар бурханы шашныг улс төр, колоничлох бодлогын арга хэрэгсэл болгон ашигласанаас үүдэлтэй сөрөг нөхцөл байдлууд бий болж, энэ нь нийт монголчуудад сөргөөр нөлөөлсөн тал ч бий. Гэвч монгол үндэстэний дунд бурханы шашин маш хүчтэй түгэн дэлгэрч, язгуурын бөө мөргөлийн шашин, уламжлалт, ёс заншил, зан суртахуун, үнэт зүйлтэй нэгдэн нягтарч бидний оршин тогтнохуйн суурь оршихуй болсон байна. Энэ талаар дотоод, гадаадын олон судлаачид өгүүлсэн буй.

1911 оны үндэсний хувьсгал, 1921 оны үндэсний ардчилсан хувьсгалаар төрийн тусгаар тогтнолоо сэргээсэн. Ардын Засгийн газраас 1921 оны 11 дүгээр сарын 01-нд Богд хаан Жавзандамба (1869-1924)-тай “Тангарагийн гэрээ” байгуулсан бөгөөд гэрээний нэгдүгээр зүйлд, “Монгол улсын Богд хаан Жавзандамба хутагт шарын шашны Богд эзэн болох тул улс төрийн хэрэгт холбогдоогүй, шашны бүх хэргийг хязгааргүй эрхэлбэл зохино” (Ц.Насанбалжир, 1954, хууд. 31) гэж заажээ. Улмаар Улсын анхдугаар Их хурлаас баталсан анхны Үндсэн хуулиар төр, шашныг тусгаарласан. Гэвч Үндсэн хуулиар ван, гүн, хутагт хувилгаад, сүм хийдэд данстай лам нар, худалдаачид зэрэг нийгмийн зарим давхаргын сонгуулийн эрхийг хасаж, анги ялгаварлах бодлогыг хуульчилсан. Энэ үеэс үндэсний соёл, шашин, зан суртахуун, үндэсний ухамсар хумигдаж хэт ангич, хувьсгалч үзэл хүчээ авсан байна.

Ийнхүү шашны эсрэг үйл ажиллагаа улам хүчээ авч олон мянган сүм хийдийг хааж, нурааж, эвдэн сүйтгэж, лам нарыг

албадан хар болгох, улс төрийн хилс хэргээр цаазлах гэх мэт бусармаг үйл хэргүүд олон жил явагдсан байна. Монгол улсад 1937 оны байдлаар 583 том хүрээ, 260 жижиг сүм дуган байсан бөгөөд тэдгээрийн 113 хийд нь 200-гаас дээш ламтай байжээ. Хүрээ хийдэд шавилан сууж байсан лам нар насанд хүрсэн хүн амын гуравны нэг хувийг эзэлж байв (Дуган ба лам нарын талын асуултууд, 1944). Харин 1937-1938 онд бүх сүм хийд, мөргөлийн газрыг хааж, лам нарыг улс төрийн хилс хэрэгт хэлмэгдүүлснээр 1939 он гэхэд Монгол оронд шашин шүтлэг бүрэн хаалттай болжээ.

Хэдийгээр замын зуурт хожим 40-өөд оны дундаас ганц хийд Гандантэгчэнлинг нээж ажиллуулсан” (Г.Лувсанцэрэн, 2008, хууд. 204) байна. Өөрөөр хэлбэл, БНМАУ-ын Бага Хурлын Тэргүүлэгчдийн 1944 оны 5 дугаар сарын 22-ны өдрийн тогтоолоор Улаанбаатар хотод Мөргөлийн дуганыг нээсэн нь уламжлалт шашин соёл дахин сэргэх эхлэлийг тавьсан. Үүний нөлөөгөөр 1944-1960 онд Улаанбаатар хот болон хөдөө орон нутагт долоон сүм хийд ажиллаж байв. Хөдөө орон нутаг дахь сүм хийдүүд 1962 он гэхэд бүгд татан буугдсан боловч Гандантэгчэнлин хийдийн үйл ажиллагаа өргөжиж, Шашны дээд сургууль байгуулагджээ.

Мөн 1960-аад оны эцсээр улс орныхоо энх тайванч гадаад бодлогыг Азийн бурханы шашинтан олны дотор таниулах, хамтын ажиллагаа өрнүүлэх зорилгын үүднээс Гандан хийдийн хамба лам номч мэргэн гавж С.Гомбожав Азийн хэд хэдэн бурханы шашны нэрт зүтгэлтнүүдийн хамт санаачилга гарган Азийн буддистуудын энх тайвны бага хурал гэдэг энхийн хөдөлгөөнийг өрнүүлсэн байна. Үүнтэй холбогдон Гандантэгчэнлин хийдийн гадаад харилцаа өргөжиж, мөн нас сүүдэр өндөр болж яваа лам нарынхаа залуу халааг бэлтгэх асуудал ч тавигдаж, 1970 онд Гандан хийдэд Шашны дээд сургууль

байгуулагдан, залуучуудыг сургаж, шашны боловсрол, орчин үеийн мэдлэгийн үндсийг эзэмшсэн лам нарыг бэлтгэх болсон байна.

Монголчуудын уламжлалт бурханы шашны түүх нь монголчуудын түүхтэй салшгүй холбоотой байж ирсэн. Тэр дундаа XX зууны түүхийн гашуун хийгээд сургамжит, гэтэлж гараад бүтээн цогцлоосон гайхамшигт үйл хэрэг хийгээд өнөөдрийн бидний аж төрж буй үйл үртэй гагнагдсан буй.

Тиймдээ ч бурханы шашны сүм хийдийг устгаж, хутагт хувилгаад, хамба лам, унзад лам гэхчилэн мяндаг тушаалтнууд, энгийн хурлын лам нарыг хүртэл хомроглон баривчилж цаазлаж, хүнд хүчир ял оноож, залхаан цээрлүүлж, айл өрхийн бурхан шүтээнийг булаан авч устган, түймэрдэн шатааж байсан ч монгол хүний ахуй соёл, амьдралын утга учраас уламжлалт соёлыг нь бүр мөсөн үгүй хийж чадаагүй юм. Тиймээс их эзэн Богд Чингис хаан аян дайны явцдаа бусдын харь шашинд хүндэтгэлтэй хандаж, “сэтгэлийг эзэмдвээс бие хаа холдох буй” хэмээсэн буй заа.

Социализмын цаг үед шашны асуудлыг эрхэлсэн Сайд нарын зөвлөлийн дэргэдэх Шашны хэрэг эрхлэх зөвлөл ажиллаж энэ институт шашны талаарх монгол төрийн бодлогыг ерөнхийд нь тодорхойлж байжээ. 1989 оны 12 сарын 19-нд “Шашны хэрэг эрхлэх зөвлөл”-өөс “Шашин шүтлэгийн байдал, энэ салбарт цаашид зохиох ажлын тухай” судалгааг нийслэл Улаанбаатар хот болон нэр бүхий 12 аймгуудын Намын хороо, АДХ-ын гүйцэтгэх захиргаатай хамтран хийсэн байна. Эндээс бид тухайн цаг үе дэх шашны талаарх олон нийтийн санаа бодол, нөхцөл байдал, төрийн байгууллагын зүгээс шашин соёлын асуудалд хэрхэн хандаж байгаа зэрэг асуудлуудыг тодруулах боломжтой юм.

Аймаг, хотуудын ирүүлсэн мэдээнээс үзвэл, шашин шүтэх явдал Дорноговь,

Дорнод, Баян-Өлгий, Хөвсгөл, Булган, Увс, Хэнтий аймагт буурах, Архангай, Баян хонгор, Завхан, Говь-Алтай аймагт өсөх хандлагатай үзүүлэлт гарчээ. Аймаг хотуудаас ирсэн мэдээ нэгдүгээрт, тус улсын дотор шашин буурах тогтвортой хандлага зонхилж байна. Шашин шүтэх явдал буурах шалтгааныг соёл, боловсрол, шинжлэх ухааны хөгжилт, сүм хийд, бурхан тахил, ном судар, лам нар зэрэг шашин шүтлэг оршин тогтнох, түгэн дэлгэрэхийн үндсийн үндэс болсон зүйлүүд нийгмийн амьдралаас аажмаар шахагдан үгүй болж байгаатай холбон үзсэн. Мөн шашин шүтэгчдийн ихэнхи нь өндөр настан, тэдний тоо, бусдад үзүүлэх нөлөө жил ирэх тутам буурч “...30-аад оны үед сүсэглэж байсан хүмүүсийн нас өнөөдөр дорж хаяж 70 гарсан” нь хүн амын шашны нөлөө буурахад хүргэж байна гэж үзсэн. Гэтэл 1990-ээд онд монгол орноо шашин шүтлэг дахин сэргэн мандахад энэ л хүмүүс номын дуу, сүм хийдийн дэг жаяг, шинэ лам нарыг шавиар бэлтгэх, сүм хийд байгуулахад ахин хуврага хувцасаа өмсөж манлайлж оролцсон юм. Жишээ нь, Увс аймгийн Улаангомд<sup>1</sup> “17-р жарны цагаан морин жилийн өвлийн адаг сарын шинийн 09-ний хөх морин өдөр цогийн наран дэлгэрэх /балжинням/, өлзий дэлгэрэх /раашням/ дараалсан гайхамшигт сайн өдөр Улаангомын Дэчинравжайлин хийдийн Чогчэн хурлыг” эхлүүлсэн. Уг Чогчэн хурлын хаалгыг хаахад байсан 83 настай Чогчэн дуганы гонир<sup>2</sup> Лэгзэн гуай Чогчэн хурлын түлхүүрийг мутарт нь залж, номын өргөөг нээжээ. Ийнхүү “...Ш.Лэгзэн (1908-1991), Г.Даржаа (1913-1993) нар дуганыг нээж дотогшоо орон мөргөл үйлдээд зул хүж өргөн чогчэн хурлыг эхлүүлэв.

Улаангомын хүрээний ууган лам нар болох Ш.Лэгзэн, Г.Даржаа, Ч.Замба (1910-1998), П.Раднаа (1917-1996) Төгсбуяантын хүрээний хувраг явсан Е.Дагиням (1913-1994), Дэжээлингийн хүрээний хувраг явсан Ч.Дорж (1908-1996), Д.Лувсан, П.Пэрэнлэй, Хан Хөхийн хувраг явсан Дайвийням нар Чогчэн хуралд анх хурсан” байна. Хурал 3 өдөр дараалан хурсан нь сүсэгтэн олны шашин соёлоо гэсэн хүлээлт ямар их байсныг илтгэнэ. Уг хуралд хувраг Ш.Чойнзон, Б.Дөш, Х.Бадарч, М.Донров, Б.Жимбэ, Г.Дэчин, А.Дамдинсүрэн нар мөн оролцсон байна. Чогчэн хурлын уншлагын дэс дараа горим жаягийг Ш.Лэгзэн, Г.Даржаа нар боловсруулсан байна.

Ховд аймагт Өөлдийн шар сүм буюу Түгээмэламаржуулагч хийдийг Буянтголын ард байсан анхны туурийг нь 1990-ээд оны эхээр 30-аад оны хэлмэгдүүлэлтээс амьд сэрүүн үлдсэн буурлууд сэргээж байгуулсан. Үүнд: өөлдийн Ганданпунцаглин хийдэд хүүхэд, залуу цагтаа шавилж байсан нас өндөр гарсан Х.Жамц, Жийжээ, н.Соном, н.Түвдэн, н.Данзан-Осор, н.Пэрэнлэй, н.Чойжоо нар, урианхай н.Донров нарын лам хуврагууд ихэнхи нь өөрийн гэр орноо барьж шашны үйл хэргийг эхлүүлсэн юм. Энэ мэтчилэн бурханы шашны төлөөлөл, сайхан буурлууд шинэ цагийн салхийг хагалж, хойч үедээ бурханы шашны соёлоо амсуулж, ухааруулаад цагийн эрхээр увж, цуван ертөнцийн мөнх бусыг үзүүлсэн билээ.

Ийнхүү монгол орны өнцөг булан бүрт шашин ном, үндэсний ухамсар, өв соёлоо сэргээн мандуулах үйл хэрэг идэвхижсэн байна. Монголын баруун бүс нутаг Ховд аймаг, Увс аймаг, Баян-Өлгий аймаг, Завхан

1 Энэхүү баримтуудыг Увс аймгийн Дэчинравжайлин хийд дахин сэргээсний 20 жилийн ойд зориулсан “Улаангомын хүрээ Дэчинравжайлин хийд” (Увс аймаг, 2011) номноос хэсэгчилэн авсан болно. Уг номыг Ариутган шүүсэн Д.Балдорж, эмхтгэн найруулсан Х.Батсүх. //Мөн уг хийдийг сэргээх, Увс аймагт бурханы шашны үйл хэргийг хуучин дэг жаягаар сэргээн хөгжүүлэх, тун чухал түүхэн баримтуудыг хадгалан, хамгаалж үлдсэн тухайн үеийн Увс аймгийн Сүсэгтний холбооны тэргүүн, Монголын Сүсэгтний холбооны тэргүүлэх гишүүн Цорос овогт Таяын Бямбадорж аругайн гавьяа зүтгэл тун их болохыг энд зориуд дурдая.

2 Гонир: хийдийн түлхүүр хариуцагч ламыг хэлнэ.

аймаг, Говь-Алтай аймгуудад хуучны томоохон хийдийн үүх, түүхийг судлах, шашин соёлыг сэргээх, шинээр сүм хийд байгуулах нэр их ажил өрнөсөн нь өнөөг хүртэл үргэлжилсээр байгаа юм.

Дээр бидний дурдсан Шашны хэрэг эрхлэх газрын баримтад “шүтэн бишрэх явдлын далд хэлбэрийн талаар” авч үзэхдээ “Шашин шүтлэгийн далд хэлбэр одоогоор бараг бүх аймагт зонхилж байна. Одоог хүртэл нэг ч аймагт, нэг ч удаа сүсэгтнүүдээс гомдол гаргаж байгаагүй нь үүний гэрч юм” хэмээн дүгнэжээ. Цаашилбал, Увс аймгийн Намын хороо, АДХ-ын гүйцэтгэх захиргаа “БНМАУ-ын Үндсэн хуульд заасан ард иргэдийн шүтэж бишрэх эрхийг сүсэгтэй хүмүүс бүрэн эдлэхгүй байгаа, тэднийг гадуурхах, хавчих явдал байсаар байгаа тул шүтэн бишрэх явдлын далд хэлбэр нь илүү байна”, “Аймаг бүрт, эсхүл хоёр буюу хэдэн аймгийн дунд сүм хийдийг сэргээвэл нэг талаас сүсэгтэн нарт чирэгдэл багасах, нөгөө талаас улсад ч зохих хэмжээний орлого орох талтай. Мөн түүх, соёлын дурсгалт барилга байгууламжууд ч эзэнтэй болж хамгаалалт нь сайжирна.” гэх мэтээр саналаа ирүүлсэн байна. Мөн ард иргэдийн дунд уул овоо, газар усыг тахих талаар уламжлал сэргэж буй талаар Завхан аймгийн Намын хороо, АДХ-ын гүйцэтгэх захиргаа “энэ жилээс эхлэн өвгөд хөгшид уул овоо тахих тухай асууж лавлах болов” гэхдээ үүнийг утга учиртай байгаль эхээ хайрлан хамгаалж ирсэн уламжлалтай сайн уялдуулах шаардлагатай байгааг, учрыг нь мэдэхгүй хүмүүс байгаль, эх уул овоог бузарлаж, хог хаягдал их бий болгож буйд шүүмжлэлтэй хандсан байна.

Энэ бүхнээс үзвэл, тухайн цагт 70 гаруй жилийн хугацаанд ор мөргүй алга болгохоор үзэл суртал, улс төрийн мөрдлөг, хавчлага, нууцын нууц эс бусын аргаар төр засгаас явуулж ирсэн бодлого нь олон нийтийн дунд оюун санаанд нь нууцлагдмал, зүрх

сэтгэлд нь мөнхөд хадгалагдаж ундарсаар ирсэн юм. Тиймдээ ч цагаан морин жилийн хувьсгалаар шашин шүтэх, эс шүтэх эрх эрх чөлөө нээлттэй болж монгол орны газар орон бүрнээ бурханы шашны аялгуут уншлага, буян номын үйл хэрэг дахин сэргэж хөгжиж эхэлсэн түүхтэй.

Аль нэг шашин нь зөвхөн үзэл санаа, номлол сургаал, сүсэг бишрэл, итгэл үнэмшил төдий зүйл биш, нийгмийн тодорхой бүлэг болон хувь хүмүүсийн шүтлэгийн үйлдэл, үйлажиллагааны тогтсон систем байдаг. Мөн нийгмийн давхраажилт, бие хүний нийгмийн статус, угсаатны бүлэг, нийгэм-эдийн засаг, эрх зүй, улс төрийн орчин нөхцөлөөс шашин нь хамаарахын зэрэгцээ эргээд тэдгээрийг тодорхойлдог. Үүний учир шашны асуудлыг судлахад дээрх хүчин зүйлсийг харгалзан үзэх нь зайлшгүй юм. Энэ бүхнийг цогцоор авч үзэхэд юуны өмнө шашныг шүтэн бишрэгч сүсэгтнүүдийн нэгдэл холбоо буюу шашны байгууллагын асуудлыг хөндөн үзэх шаардлагатай. Шашны байгууллага гэдэг нь хамгийн ерөнхий утгаараа “шашны итгэл бишрэл ба зан үйлийн нийтлэг байдалд үндэслэсэн нэгэн ижил шүтлэгтнүүдийн зохион байгуулалт бүхий нэгдэл, холбоо” юм (А.А.Радугин, 1997, хууд. 38). Харин явцуу утгаараа “сүсэгтэн олны шашин номын эрэлт, хэрэгцээг хангах зорилгоор байгуулагдаж, шашны зан үйл, хурал ном, боловсролын ажлыг эрхлэн гүйцэтгэж буй албан ёсны зөвшөөрөл бүхий хийд, сүм, дацан, төв болон тэдгээрийн удирдах байгууллагыг шашны байгууллага”<sup>3</sup> (Монгол улсын төр, сүм х)гэнэ.

Бид өнөөгийн монголын баруун бүс нутагт үйл ажиллагаа явуулж бурханы шашны сүм хийд, шашны байгууллагын талаар энд тодруулан авч үзэх болно.


Баруун бүс нутгийн хэмжээнд бидний явуулсан хээрийн судалгааны үр дүнгээс

3 Монгол улсын төр, сүм хийдийн харилцааны тухай хууль // Төрийн мэдээлэл. 1993. №7, тал.820-825.

харахад буддын шашны чиглэлээр Ховд аймагт сүм хийд 13, Увс аймагт сүм хийд 16, дуган 1, Завхан аймагт сүм хийд 29, дуган 1, Говь-Алтай аймагт сүм хийд 11, дуган 2, Баян-Өлгий аймагт сүм хийд 2, дуган 1 нийт хийд 72, дуган 5 байна. Эдний аймгийн төвд буй 12 сүм хийд, 1 дуган буюу Ховд аймгийн 2, Увс аймгийн 3 (дуган 1), Завхан аймгийн 5, Говь-Алтай аймгийн 1, Баян-Өлгий 1 тогтмол, харин сум, сууринд буй 60 орчим сүм хийд үйл ажиллагаа явуулж байна. Тэдгээрийн 12 нь аймгийн төвд, 60 нь бусад сум, суурин газарт буян номын үйл эрхэлж байна.

Монгол Улсын Үндсэн хуулинд: “Төр нь шашнаа хүндэтгэж, шашин нь төрөө дээдэлнэ”, Төр сүм хийдийн харилцааны тухай хуульд “Төрөөс Монголын ард түмний эв нэгдэл, соёл иргэншлийн

түүхэн уламжлалаа эрхэмлэхийн үүднээс Монгол Улс дахь буддын шашны зонхилох байр суурийг хүндэтгэн үзнэ. Энэ нь иргэд бусад шашин шүтэхэд саад болохгүй” гэж заасан буй. Энд нэг зүйлийг зориуд дурдахад уламжлалт шашны сүм хийдүүдэд төрөөс нэг удаа дэмжлэг үзүүлэх, тодорхой соёлын бодлогод тусгаж санхүүгийн хувьд дэмжих нь ямар ч хууль эрх зүйд нийцэх учиртай. Тухайлбал, Монголын баруун бүс нутагт нийт буддын шашны 72 сүм хийдийг сүүлийн 30 жилийн хугацаанд төр засгаас нэг ч төгрөгний хандив дэмжлэггүйгээр сайн санаат хүмүүс болон нутаг нуга, өвөг дээдэс, үндэсний соёлоо гэсэн чин сэтгэлтэй олон түмэн, нутгийн зөвлөлүүд төсөл санаачлан хувийн хандив хөрөнгөөр бүтээн босгожээ.



Баруун бүсийн буддын шашны байгууллага нь хүчин чадал, хамрах хүрээ, лам хуврагийн хувьд харилцан адилгүй. Баян-Өлгийгөөс бусад дөрвөн аймгийн төвд байдаг буддын шашны байгууллагууд нь хүчин чадлын хувьд тэргүүлэх байр суурьтай. Аймгийн төв, хүн ам харьцангуй олноор суурьшсан сум, суурин газарт байгаа сүмүүд нь хурал номын үйл хэргийг өдөр бүр эрхлэхийн зэрэгцээ, лам хуврагууд нь иргэдийн хүсэлтээр буяны ном унших, сан тавих г.м. үйл хэргийг хувиараа эрхэлдэг. Харин сум, суурин газарт буй сүм хийдүүдийн үйл ажиллагаа нь улирлын шинж чанартай, зөвхөн дүйчин өдрүүдэд хурал ном хурж, бусад үед нь иргэдийн хүсэлтээр айл өрхөөр явж ном унших, бурхан болоочдын хойтоход зориулан буян үйлдэх г.м. үйл эрхэлдэг юм.

Буддын шашны чиглэлээр үйл ажиллагаа явуулж буй шашны байгууллага сүм хийдүүдийн тухайд Монголын Бурханы шашны төв Гандантэгчилэн хийдэд нийслэлийн дүүрэг (9) болон аймгуудын сүм хийдүүдийн (21) тэргүүн нар, зарим хувийн сүм хийдийн төлөөллөөс бүрдсэн Тэргүүн лам нарын зөвлөл ажилладаг. Тэргүүн лам нарын зөвлөл нь Монголын Бурханы шашны бодлого, хэтийн төлөв, бие даасан байдал, эв нэгдэл, шүтэн бишрэх эрх, эрх чөлөөг дээдлэн хангахад чиглэгдсэн эрх барих дээд байгууллага юм.

Зөвлөлийн хуралдаанаар бурханы шашны үйл ажиллагааны ерөнхий бодлого тодорхойлох, сахил санваар, винайн ёсыг сахиулахад анхаарах, дүрэм журам, дэг жаяг, сүм хийдийн үйл ажиллагааны стандарт батлах, хутагт хувилгаадын асуудал /уламжлалт тамга шарлуулах ёс/, тулгамдаж буй асуудлыг шийдвэрлэхэд чиглэгдэнэ. Дүүрэг болон аймгуудын хамба ламыг зөвшөөрч батламж, жанч, олбог /ямба/ өгнө. Харин дүүрэг, аймаг, орон нутгийн сүм хийдүүд хурал номын үйл хэргээ дээрх жаяг, гаргасан шийдвэр, бодлого

чиглэлд нийцүүлэн өөр өөрийн онцлогийг харгалзан явуулна. Санхүүгийн тухайд сүм хийдүүд өглөгийн эзний хандив тусламж, үйл ажиллагааны орлого /ном хурах, буяны ажил/-оор санхүүжнэ. Буяны ажлын үнэ тарифийг өөр өөрсдөө тогтооно. Билгийн тооллын зуны эхэн сарын 15-нд Бурхан багшийн их дүйчин өдрийн хурал хурна. Энэ өдөр Бурхан багшийн мэндэлсэн, гэгээрсэн, бурханы хутаг нирваань дүрийг үзүүлсэн гурван үйл давхацсан бэлэг дэмбэрэлтэй өдөр байдаг. Эл өдрийг буддын шашинтай дэлхийн бүх улс орон тэмдэглэдэг. Богд Зонховын дүйчин өдөр буюу Зулын 25 (өвлийн эхэн сарын 25), Бурхан багшийн эхийн ачийг хариулсан өдөр, Өвлийн адаг сарын шинийн 24-с эхлээд 29-ныг хүртэл хурал хураад, Битүүнд Цэдэр Лхамд балин өргөх хурлыг хурна.

Баруун бүсийн сүм хийдүүд шинийн 16-нд Майдар эргэх ёслол үйлдэж, хурал хурдаг онцлогтой. Сүүлийн үед бурханы шашны сүм хийдүүд нийгэм рүү чиглэсэн хүмүүнлэгийн болон бусад төрлийн хөтөлбөр хэрэгжүүлэх болсон нь нэн сайшаалтай. Мөнцахимаар хурал, ном хурах, номын утга холбогдол, үр дагавар, иргэдийг соён гэгээрүүлэх чиглэлийн ажлууд зохион байгуулж байна<sup>4</sup>. Тухайлбал, Баруун бүсийн томоохон шашны байгууллагын нэг Ховд аймаг дахь Ганданпунцагчойлин хийд нь 2009 онд өглөгийн эздийн хандиваар байгуулагдсан. Хийдэд ловон лам-1, гэсгүй-1, унзад лам-1, зурхайч-1, балин тахилч-2, багш лам-2, хурлын лам-4, нийт 10, дээр нь нягтлан-1, манаач-1, цэвэрлэгч-1 гэсэн 15 хүний бүрэлдэхүүнтэй ажиллаж байна. Лам нар хөдөлмөрийн хөлсний доод хэмжээгээр цалинжахын зэрэгцээ хувиараа албан байгууллага, айл өрхөд ном унших, бусад буяны ажилд оролцсоны өглөгөөр санхүүждэг (Ойрад судлал: өнөө ба ирээдүй, 2011, хууд. 150-152).

<sup>4</sup> Зохиогчийн хувийн архив (Ховд аймаг. Ганданпунцаглин хийд. Ярилцлага өгсөн хамба лам Б.Соёл-Эрдэнэ)

Тэгвэл Завхан аймгийн ТөгсБуянтЖавхлант болон Дэцэндаржаалин хийдүүд нь нэгдсэн зохион байгуулалтаар үйл ажиллагаа явуулдаг. Дэцэндаржаалин хийд 1990 онд Дилав хутагт Жамсранжавын Улаан сүм гэж байсны туурь нь дээр Алтан элсний ам гэдэг газар аймгийн төвд байгуулагдсан. Дилав хутагт Манжийн амбаны хүчийг сарниулах зорилгоор байгуулж Жамсран бурхан тахиж тогтмол гүрэм хийдэг байснаар дайсны хүч суларсан хэмээн ард иргэд домоглож ярьдаг. Харин ТөгсБуянтЖавхлант хийд нь Завхан аймгийн 80 жилийн ойгоор (2003.Х.12) олон нийтийн хандиваар аймгийн төвийн Жавхлант толгой дээр байгуулагдсан. Бүтэц, зохион байгуулалтын хувьд энэ хоёр хийд нэгдсэн зохион байгуулалттай нэг хамба лам, дэд хамба, ловон лам, да лам, унзад лам, гэсгүй лам, цорж лам, чомбо буюу тахилч лам, их, бага унзад лам гэсэн зэрэг дэвтэй, нийт 60 орчим лам байна. 1990-ээд оноос хойш Энэтхэгт 140 гаруй хүүхэд суралцан төгсөж ирсэн, одоо 30 орчим ламхай сурч байна. 1939 оноос хойш тасраад байсан “Дооромбо”<sup>5</sup> (Бурхан шашны нэрийн тайлбар толь, 2015, хууд. 31)-ын зиндааг Энэтхэгт хамгаалсан н.Шаравдорж ламтан энд ажилладаг ажээ. Харин сумууд тухайн сүм хийдийг хариуцсан нэг голлох лам буюу хамба ламтай бусад нь хурлын лам байна. Сумуудын сүм хийдийн үйл ажиллагаа тогтмол бус байна. Буддын сүм хийдүүд сум, сууринд цор ганц байх боловч эдийн засгийн эх үүсвэр хязгаарлагдмал, хүн амын олонхи нь хөдөө малчин, сүмд өдөр бүр ирээд мөргөл, залбирал хийх сүсэгтэний хэрэгцээ бага зэрэг нь үнэндээ бэрхшээл болдог. Хэдийгээр барьж байгуулахад тал талаасаа хамжиж, хандив, өргөлөөр босгодог боловч цаашид хэрхэх асуудлыг анхнаасаа орхигдуулдаг, бодлого, тооцоолол байхгүй, ажиллуулах нь зөвхөн тухайн сүм хийдийн хамба ламын асуудал болж хоцордог нь үйл

ажиллагаа тасалдах, цаашилбал зогсоход хүргэдэг.

Буддын шашны хийд байгуулахад 1990-ээд онд 25-30 сая орчим саяд, 2000 он гараад 80-100 орчим сая (Үенч сумын Баянмандал хийд, 2014 онд байгуулагдсан, хувь хүний хандив голлосон, Монгол Улсын онц бөгөөд бүрэн эрхт элчин сайд, олон улсын харилцааны доктор, Сүхбаатарын одонт Г.Батсүх - 42 сая төг, бусад хандив 20,23 сая төг) зарцуулсан бол дахин 2018 онд 25 сая төгрөгийн нэмж засвар хийсэн байна. Тэгвэл 2021 онд байгуулагдсан хийд 350 сая орчим төгрөг (Эрдэнэбүрэний Ганданпунцаглин хийд, олны хандив, УИХ-ын гишүүн С.Бямбацогт 35 сая төг, Хар чонот компаний захирал н.Баянцагаан 10.2 сая төг, МУ-ын харцага Т.Амартүвшин 5 сая улс, аймгийн аварга малчид 10 эр хонь г.м.)-т бүтээгдсэн байна. Хандивыг тоймлон дурдахад: улс, аймаг, сумын аварга малчид тус бүр 10-с дээш тооны эр хонь, хамгийн багадаа иргэд 100.000 төгрөг хандивласан байна. Энэ нь нийт 4 өөр дансаар орж ирсэн дүн нь 1-р данс 64,481,999, 2-р данс 14,5 сая, 3-р данс 37,8 сая, 4-р данс 22,6 сая, үүн дээр нэмэгдээд 7 сая, 2,2 сая, 55,9 төгрөгүүд хандивын дансанд орж ирсэн. Намар хийдийн нээлт хийсэн санхүүгийн тооцоогоор 209,565,331 төгрөг цугларч уг мөнгийг хийдийн бүтээн байгуулалтанд зарцуулжээ. Зарцуулалтыг харвал, оёдол (10.035.000), бурхад 7 ширхэг, суврага, бодь гөрөөс (22.600.000), бурханы шүншиг (3.434.500), хийдийн тааз (7.067.600), гүнгэрваа, ламын ширээ, жавдан (70.400.000), зуу бурхан бүтээхэд (4.200.000), сүсэгтний суух сандал (540.000), барилгын материалд 57.187.388, ажилчдын цалин 21.150.000 төгрөг зарцуулжээ. Нийт 350 сая төгрөгт багтсан бүтээн байгуулалт болсон байна. Шашин, соёл, ёс уламжлал, үнэт зүйлээ хөхиүлэн дэмжиж, их бүтээн байгуулалт, хандив цуглуулж сүм хийд босгожээ. Харин цаашид яах бэ?, хэрхэн

5 Төвөдийн Лаврин хийдэд очиж чулуун суудалд сууж хамгаалдаг байсан эрдмийн зэрэг.



хамгаалах, хадгалах, өргөжүүлэх, түгээх, суртачилах, тогтмол ажиллуулах г.м. маш олон асуудалд эрх бүхий соёлын яам нэг хариулт өгч, төр засаг нэг шийдвэр гаргах хэрэгтэй.

Баруун бүс нутагт сумын төвд байршилтай сүм хийдүүдийн ойролцоогоор гуравны нэг нь хариуцсан ламтай (өөрийн орлогоор санхүүждэг), манаачтай (хөдөлмөрийн хөлсний доод хэмжээгээр цалинждаг), дүйчин өдрүүдэд ном хурдаг, иргэдийн хэрэгцээтэй үед нь (нас барагсдын хойтын буян, аян замын ерөөл, хийморийн сан, янз бүрийн засал г.м.) хийдүүд хурал хурах, буяны ном хурах чиглэлээр харьцангуй тогтвортой ажиллаж байгаа бол бусад нь үйл ажиллагаа нь түр болон бүрэн зогссон байна. Орон нутаг, суманд байгуулагдсан сүм хийдүүд нь нэг талаас шашны байгууллага мэт боловч монголчуудын биет болон биет бус соёлын өв, ариун дагшин газар орон, соён гэгээрлийн ил уурхай юм. Энэ сүм хийдүүд нэг бүр нь дунджаар 50-350 орчим сая төгрөг түүнээс дээш хөрөнгөөр бүтээгдсэн, уламжлалт монгол сүм хийдийн хэв загвар, дотоод засал чимэглэл, ур ухааныг шингээсэн, нүүдэлчдийн олон мянган жил бүтээсэн судар ном, бичиг үсгийн дурсгал хадгалагдсан, нэгэн цаг, нэг хүний түүх бус харин гурван цагийн хэлхээгээр холбогдсон, нийт монгол түмний шавхагдашгүй түүх, үнэт баялаг мөнөөс мөн бөлгөө.

Гэтэл тэдний аймгийн төвийн сүм хийдүүд Тухайлбал, Ховд аймгийн Ганданпунцагчойлин хийд, Завхан аймгийн ТөгсБуянт Жавхлант хийд, Увс аймгийн Дэчинравжаалин хийд, Говь-Алтай аймгийн Дашпэлжээлэн хийд, Баян-Өлгий аймгийн Раашгэмпилэн хийд (гэр дуган) тогтмол ажилладаг. Харин сумын төвд байгуулагдсан хийдүүд боловсон хүчин, санхүүгийн байдал, амьдралын нөхцөл, хэт алслагдмал байдал зэргээс хамаараад ажиллахгүй хаягдаж үрэгдэж, буцаад устаж

үгүй болох хэмжээнд хүрээд байна. Яагаад бид үндэсний соёлын энэ том бүтээлээ чимээгүй харсаар буцааж мөхөлд хүргэх гээд байна бэ? гэдэгт дээр доороо анхаарч яаралтай тодорхой шийдэл гаргах хэрэгтэй байна. Нэн ялангуяа уламжлалт бурханы шашны хийд орны тухайд эрх зүйн шинэ орчны зохицуулалт чухал байна. Юуны өмнө эдгээр сүм хийдүүдийн албан ёсны бүртгэл хийх, бурхан шүтээн, судар номыг бүртгэх үнэлэх, соёлын үнэт зүйлийнх нь хувьд баримт, зургийг нь баталгаажуулах, олон нийтэд суртачилах гээд хэлж барамгүй их ажил байна. Улаанбаатарт улсын хөрөнгөөр байгуулсан Чингис хаан музейний орон нутгийн салбарууд нь яагаад сумын сүм хийдүүд байж болохгүй гэж. Шийдэж бодит ажил болгох нь чухал байна. Жишээ болгон хоёр хийдийн зураг оруулья! (Завхан аймаг, Цэцэн-Уул сум, Ганданпэлжээлэн хийд. 1990 онд байгуулагдсан), (Завхан аймаг, Цагаанхайрхан сум, бүр мөсөн устгагдаж буй, бүртгэлд байхгүй)

Буддын хийд нь христос болон ислам шашныхийдээс ялгагдах өвөрмөц онцлогтой учир байгуулах санхүү өндөр зарцуулагдаж (сүмийн барилга, гоёл чимэглэл, бурхан шүтээн, ном судар, зул, хүрд, суварга гэх мэт) байгуулсан хойно нь уг соёлын үнэт зүйлсийг хамгаалах, хадгалах, байнгын эргэж тойрч нандигнаж байх гэх мэтээр маш олон шийдэл бүхий эдийн засгийн эх үүсвэрүүдийг шаардаж байдаг онцлогтой. Нөгөө талаас бурханы шашны сүм хийд нь монголчуудын хувьд хамгийн ариун нандин, дагшин газрын нэг байсаар ирсэн төдийгүй соёл, мэдлэг ухаан, боловсролын чухал институт юм. Тиймээс өвгөд ном дор мөргөмүй, багш дор мөргөмүй, хувраг дор мөргөмүй хэмээн бурхан багшийн гурван чухаг эрдэнийн шүтэж ирсэн уламжлалтай. Иймд миний бие сум сууринд байгуулагдсан буддын хийдүүдийг сумын музейтэй нэгтгэн зохион байгуулалтанд оруулж, төрөөс тодорхой орон тоог батлан



үйл ажиллагааг нь явуулах шийдэл байж болох саналыг дэвшүүлж байгаа юм.

Баруун бүс нутагт 2010 оны байдлаар нийт 64 орчим хурлын лам шашин ном, буяны үйл хэрэг эрхэлж байгаа статистик байна. Харин 2021 он гэхэд энэ тоо 250 болж өссөн байна (Монгол Улсын Үндэсний статистикийн хороо). Арав орчим жилийн хугацаанд 3 дахин өсжээ. Тэд монголдоо шашны дээд боловсрол эзэмшсэн, эсвэл гэрээр болон бие дааж ном сурсан байхын зэрэгцээ Энэтхэгт суралцсан хүмүүс байна. Олонхи нь 30-40 настай. Өнөөдрийн санваартнууд бол сүсэгтэн, сүм хийдийн завсарт зуучлагч мэт боловч тэдний нийгмийн үүрэг, ялангуяа нийгмийн давхраажилд үзүүлэх нөлөө багагүй юм. Шашин хязгаарлагдмал ба нууцлагдмал байдлаасаа чөлөөлөгдсөн нөхцөлд түүний нөлөө ач холбогдол сүсэгтнүүдээс урьд санваартнуудаас түлхүү хамаарах шинжтэй юм. Сүүлийн дөрвөн жилийн байдлаар Баруун бүсийн аймгуудад буддын сүм хийдэд шавилан суралцагчдын тоо болон гэрээр шашны ном заалгадаг хүүхдийн тоо 20-25 орчим байна (Н.Даваасүрэн, 2010, хууд. 358). Гэтэл арван жилийн дараа энэ тоо 2017 онд 11 (Завхан 10), 2018 онд 9 (Завхан 3), 2019 онд 20 (Завхан 15), 2020 онд 7 (Завхан 6), 2021 онд 8 (Завхан 6) болж буурчээ (Монгол Улсын Үндэсний статистикийн хороо). Эдгээрийн олонхи нь Завхан аймагт харьяалалтай байна. Хээрийн судалгааны дүнгээр 2022 оны



байдлаар Завхан аймгаас 30, Ховд аймгаас 15, Увс 5, Баян-Өлгий 2 нийт 50 гаруй ламхай Энэтхэгт шашны сургуульд сурч байна. Нэгэн жаахан ламхай хүү хувраг дотроос Далай лам хамгийн ариун нь тэр эхнэргүй, эд хөрөнгөгүй, жинхэнэ гэгээрсэн хүн хэмээн ярьж буйтай судалгааны үед таарч явлаа. Ер нь л орчин цагийн хувраг, санваартны нийгмийн төрх өмнөхөөс эрс өөрчлөгдсөн буй.

Өнөөгийн санваартнууд бол өнгөрөгч зууны лам хуврагаас нэлээд өөр нийгмийн байдал, дүр төрхтэй юм. Тэр нь нэг талаас лам хуврагийн сахил санваар, дэг жаяг, винайн ёс, зан үйл зэргээс, нөгөө талаас орчин үеийн монголын нийгэм дэх иргэний амьдралаас шалтгаалж, түүгээр нөхцөлдөж байна. Сүм хийдийн болон иргэний амьдрал урьд тусдаа, хүрээ гороогоор хатуу чанд гэмээр зааглагдаж байсан бол одоо хурал номын бус цагаар лам нарын амьдрал, хувцаслалтыг эс тооцвол ялгарахгүй шахам болжээ. Лам хуврагийн даяанч, гоонь, бясалгагч амьдрал өөрчлөгджээ.

Түүхийн чухал нь сургамж юм. Алдаагаа дахин үл давтах үйл хэрэг мөн. Алдаанаасаа сурч ашид мөнх оршихуй мөн. Гурван цагийн хэлхээний утга учир, шалтгаант холбоо, мөн чанарыг танин мэдэж, нээн олох нь хүмүүний үүрэг. Бид шашин соёл, үндэсний ухамсар, ер нь монголын гэсэн бүхэндээ дайсан мэт хандаж байсан үе бий. Өнөөдөр ч энэ нь амь бөхтэй байсаар байна.

Цаашид ч байх л байх. Гэхдээ жингийн туухайн дээр монгол шашин соёл, үндэсний үнэт зүйл маань дийлж бас онцгойрч байх учиртай.

Эрт үеэс уламжилж ирсэн бурханы шашны соёл уламжлал, сүм хийдийг босгосон буянт хүмүүс, өглөгийн эздийн бүтээн байгуулалт, үнэт соёлыг хайрлан хамгаалахад төр засгийн оролцоо хамгийн чухал юм. Шашин сүм хийд тэр дундаа бидний уламжлалт шашин хэзээ ч цэвэр бизнесийн байгууллага, ашиг орлогоороо оршин тогтнодог тийм байгууллага байх ёсгүй. Ямар ч цаг үед үндэсний соёл, уламжлалаа хамгаалж, хайрлах, хөгжүүлэх нь тэр үндэстний, угсаатны асуудал байдаг.

Төр, сүм хийдийн харилцааны тухай хууль дахь төр нь шашнаа хүндэтгэж, шашин нь төрөө дээдлэх зарчимд төр, сүм хийдийн харилцаа үндэслэнэ гээд төрөөс Монголын ард түмний эв нэгдэл, соёл иргэншлийн түүхэн уламжлалаа эрхэмлэхийн үүднээс Монгол Улс дахь буддын шашны зонхилох байр суурийг хүндэтгэн үзнэ<sup>6</sup> хэмээх заалт нь бурханы шашны талаар баримтлах төрийн бодлогын суурь зарчмыг илэрхийлдэг. Иймд нэгдүгээрт: аймаг, сум орон нутагт буй бурханы шашны сүм хийдүүдийг удирдлага зохион байгуулалтын хувьд музейтэй нэг харьяалалд аваачиж төрөөс санхүүжүүлж байх. Хоёрдугаарт: Бурханы шашныг шинэчлэх, шинэчлэлийг орчин цаг, ирээдүйн ухамсартай, боловсролтой, соёлтой сүсэгтэний хэрэгцээг хангасан, мөн тийм сүсэгтнийг бий болгох аргагүй, нийгмийн үйл хэрэг, хариуцлагын механизмтай болгоход анхаарах. Үүний учир уламжлалыг судлах, ирээдүйг төлөвлөж хооронд нь зохистой харшуулахад оршино.



Ховд аймаг, Эрдэнэбүрэн сум Гандантунцаглон хийд (2021.10.20. гадна, дотно тал.)

### Ном зүй

1. Ардын засгаас 1921-1924 онуудад авсан хувьсгалт арга хэмжээнүүд (Баримт бичгийн эмхтгэл). Эмхтгэсэн Ц.Насанбалжир. УБ.,1954.
2. “Дуган ба лам нарын талын асуултууд” - //МУУТА-ын ТБА х-1, д-6, хн-592.
3. Зава Дамдин Лувсандаян. Их Монгол оронд бурханы шашин дэлгэрсэн түүх, Алтан дэвтэр. УБ.,2014.
4. Лувсанцэрэн Г. Буддын гүн ухааны онол, түүхийн асуудлаас. УБ.,2008.
5. Монголын хууль тогтоомжийн түүхэн эмхтгэл. Нэгдүгээр боть (1206-1910 он). УБ.,2010.
6. Монгол улсын төр, сүм хийдийн харилцааны тухай хууль // Төрийн

<sup>6</sup> Төр сүм хийдийн харилцааны туха Монгол улсын хууль.4.1, 4.2. дахь заалт.

мэдээлэл. 1993. №7

7. Радугин А.А. Введение в религиоведение. М.,1997.
8. ХИС, НХУС. Ойрад судлал: өнөө ба ирээдүй (Олон улсын эрдэм шинжилгээний бага хурлын илтгэлүүдийн эмхтгэл) УБ.,2011.
9. Эх сурвалж. Монгол Улсын Үндэсний статистикийн хороо.//шашны сургууль дацанд суралцагчдын тоо.

***Abstract***

*This article examines the historical and current situation of Buddhist temples. However, he raised the issue of newly established and functioning temples in the western region of Mongolia.*